

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИД

Тодруулгад хариу хүргүүлэх нь:

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр урилга илгээсэн ЭАРХХК/20240103244 тоот “Гидрогеологийн өрөмдлөгийн ажил”-ын гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой оролцогчоос ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд :

№	Тодруулга	Хариу
1	Ажлын техникийн даалгаварт тусгасан "Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Усны газрын 2022/06/06-ны өдрийн 01/654 дугаартай албан бичгийн дагуу" гэсэн хэсгийн албан бичигтэй танилцах.	Уг нэмэлт бичгийг хүчингүй болгосон байх тул Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А-173 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Тендерийн ажлын даалгаварт тусгасан "Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ" гэсэн ажилбаруудыг тодруулах хүсэлттэй байна?	Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсны дараа судалгааны ажлын явцад нэмэлт ажил гарсан тохиолдолд уг нөхцөлийг гэрээнд нэмэлт байдлаар тусгаж ажиллана.
3	Нийт хэдэн тууш метр өрөмдлөг хийх вэ?	1.Талбайн геофизикийн ажлыг хэтийн төлөв бүхий талбайн хэмжээнд хийх./Усны хайгуул буюу ВЕЗ/ 2.Усжилт өндөртэй байх хэд хэдэн цэгүүдийг тогтоож гидрогеологийн цооног төлөвлөх. /Уг ажил нь гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажлын суурь судалгаа болно./

СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО
2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр